ГИШҮҮНЧЛЭЛИЙН БОДЛОГО

Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Институт

24/11/2025

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлтийг санаачилсан	Өөрчлөлтийг баталсан
2025.04.21	Хүрэл гишүүний ангиллыг хассан. Гишүүдэд өгөх үйлчилгээний төрөлд өөрчлөлт оруулсан	Ж.Алтангэрэл, ММЗИ УЗ гишүүн, гишүүнчлэлийн хорооны дарга	ММЗИ Удирдах зөвлөл
2025.11.24	Суралцагч гишүүн нэмсэн, Гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхой болгосон, гишүүнчлэлийн боломж, бартер ба хураамж хөнгөлөх нөхцлийг шинэчилсэн	Г.Цогтбаатар, ММЗИ Ерөнхийлөгч	ММЗИ Удирдах зөвлөл

ГИШҮҮНЧЛЭЛИЙН БОДЛОГО

Агуулга

1. ЕРӨНХИЙ 2
2. ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ 2
3. ҮЙЛЧИЛГЭЭ БА ХӨНГӨЛӨЛТ 3
4. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТӨРӨЛ БА ХУРААМЖ 6
5. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖИЙГ БАРТЕРААР БОЛОН БУСАД НӨХЦЛӨӨР ТӨЛӨХ, ХӨНГӨЛҮҮЛЭХ БОЛОМЖ 6
6. ЦУЦЛАЛТ, БУЦААН ОЛГОЛТ 7
7. БУСАД 7

ХАВСРАЛТ 8
Нэр томьёоны тайлбар 8

Гишүүнчлэлийн бодлого

1. ЕРӨНХИЙ

1.1 ММЗИ нь зөвлөх компани, ТББ болон бие даасан зөвлөхүүдийн гишүүнчлэлээс бүрдсэн, тэдний эрх ашгийг хамгаалах, ур чадварыг хөгжүүлэх, дотоод гадаадын түншлэл хүрээгээ тэлэхэд хувь нэмэр оруулах, зөвлөх үйлчилгээний зах зээлийг хөгжүүлэн олон улсын түвшинд хүргэхийг зорин байгуулагдсан ашгийн бус, төрийн бус байгууллага юм.

1.2 ММЗИ-ийн гишүүнчлэлийн бодлого нь

a) гишүүдийн зөвлөх ур чадварт мэргэших, хөгжих, хамтран ажиллах замаар зөвлөх үйлчилгээний үндэсний зах зээлийг хөгжүүлэх, олон улсын түвшинд мэргэшсэн менежментийн зөвлөхүүд бий болгоход дэмжлэг туслалцаа үзүүлэх, бэлтгэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, авахад бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллана.

b) Түүнчлэн зөвлөх үйлчилгээ авах зорилгоор гишүүнээр элссэн бизнесийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тэдэнтэй хамтдаа хөгжихөд чиглэгдсэн мэргэжлийн туслалцааг хөнгөлөлттэй нөхцөлөөр үзүүлдэг байна.

1.3 ММЗИ-ийн гишүүнчлэл нь сайн дурын үндсэн дээр байх ба ММЗИ-д жилийн аль ч үед шинээр элсэн орох боломжтой байна.

2. ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Гишүүнчлэлийн төрөл, тавигдах шаардлага: ММЗИ-н гишүүнчлэл нь дараах үндсэн 4 төрөлтэй байх ба суралцагч гишүүнээс бусад гишүүд нь бакалавраас доошгүй албан ёсны боловсролын зэрэгтэй, ажлын туршлагатай байхыг шаардана.

2.1.1 Түвшин 1. Суралцагч гишүүн (Student member): *Шаардлага:* *Менежментийн зөвлөх үйлчилгээний салбарыг сонирхогч, зөвлөх үйлчилгээ ирээдүйд эрхлэх сонирхолтой, одоо их дээд сургуулийн бакалавр ба түүнээс дээш түвшинд суралцагч оюутан байх.* ***Боломж:*** *ММЗИ-д сайн дурын ажил хийх, ММЗИ-ээс явуулах сургалт, арга хэмжээнүүдэд төлбөргүй эсвэл хөнгөлттэй үнээр оролцох.*

2.1.2 **Түвшин 2. Мөнгөн гишүүн (Silver member): *Шаардлага:*** *Менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй, зөвлөхийн ёс зүйн сургалтад хамрагдсан гишүүн (Гишүүнээр элсэх үед ёс зүйн сургалт өгөгдөнө).* ***Боломж:*** *ММЗИ-ийн гүйцэтгэх баг, хороодод гишүүнээр элсэж үйл ажиллагаанд оролцох, ММЗИ-ээс явуулах сургалт, арга хэмжээнүүдэд төлбөргүй эсвэл хөнгөлттэй үнээр оролцох.*

2.1.3 **Түвшин 3. Алтан гишүүн (Gold member)**: ***Шаардлага***: 3-аас доошгүй жил менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй, зөвлөх үйлчилгээний олон улсын ISO20700 стандарт, эсвэл зөвлөхийн ур чадварын сургалтад хамрагдсан гишүүд. Хэрэв зөвлөх туршлагын шаардлага хангасан ч сургалтын шаардлага хангаагүй бол эхлээд Мөнгөн гишүүнээр элссэний дараа ММЗИ-ээс зохион байгуулах ISO20700, эсвэл Зөвлөхийн ур чадварын сургалтад хамрагдах байдлаар гишүүнчлэлээ ахиулж Алтан гишүүн болох боломжтой (эвсэл зөвлөх нь хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын байгууллагын ижил төстэй сургалтад хамрагдсан байж болно). ***Боломж:*** Алтан гишүүд нь ***MCMC буюу Mongolian Certified Management Consultant (ММЗИ-ээс олгоно) цол, тэмдэгт*** өргөдөл өгч, үнэлгээнд орох боломжтой. *Мөнгөн гишүүнчлэлийн боломжуудыг эдлэхээс гадна гүйцэтгэх хороодын удирдлагад нэр дэвших замаар үйл ажиллагаанд оролцох.*

2.1.4 **Түвшин 4. Цагаан алтан гишүүн (Platinum): *Шаардлага***: 5-аас доошгүй

жил менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй, зөвлөх үйлчилгээний олон улсын ISO20700 стандарт, эсвэл зөвлөхийн ур чадварын сургалтад хамрагдсан гишүүд. Хэрэв зөвлөх туршлагын шаардлага хангасан ч сургалтын шаардлага хангаагүй бол эхлээд Мөнгөн гишүүнээр элссэний дараа ММЗИ-ээс зохион байгуулах ISO20700, эсвэл Зөвлөхийн ур чадварын сургалтад хамрагдах байдлаар гишүүнчлэлээ ахиулж Цагаан алтан гишүүн болох боломжтой (эвсэл зөвлөх нь хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын байгууллагын ижил төстэй сургалтад хамрагдсан байж болно). ***Боломж:*** Цагаан алтан гишүүд нь ***CMC буюу Certified Management Consultant*** *(ICMCI-аас олгоно)* ***Олон улсын цол, тэмдэгт*** өргөдөл өгч, үнэлгээнд орох боломжтой. Алтан гишүүний боломжийг эдлэхээс гадна *ММЗИ-ийн удирдах зөвлөлд нэр дэвших, сонгогдох замаар үйл ажиллагаанд оролцох.*

2.2 Хэн хамрагдах: Сонирхогч хувь хүн, эсхүл байгууллага, нь Гишүүнчлэлийн төрлөөс өөрийн хэрэгцээ, сонирхолд тулгуурлан сонголтоо хийх эрхтэй.

2.3 Хураамж: Гишүүнчлэлийн хураамжийг энэ баримт бичигт тогтоосон нөхцөлийн дагуу төлөх үүрэгтэй.

2.4 Хугацаа: Гишүүнчлэлийн хүчинтэй байх хугацаа нийт 12 сар байна. Гишүүний хураамж төлсөн өдрөөс эхлэн гишүүнчлэлийн хугацааг тооцно. Гишүүнчлэлийн төлбөр хураамжийн процессын хүндрэлийг бууруулах зорилгоор ММЗИ-ийн гүйцэтгэх баг нь гишүүнчлэлийн хураамжийг тухайн жилийн 12 сар болон дараа жилийн 1 сард нэгдсэн журмаар цуглуулж болно. Энэ тохиолдолд гишүүнчлэлийн төлбөрийг гишүүдээс тухайн хугацаанд ногдох дүнгээр авна. Тухайлбал, гишүүн нь тухайн жилийн 7 сард элссэн бол ММЗИ-д тухайн жилийн үлдсэн 5 сард ногдох гишүүнчлэлийн төлбөрийг авна. Бодлогыг ММЗИ-ийн гүйцэтгэх баг гишүүдийн хэрэгцээнд тулгуурлан шийднэ.

2.5 ММЗИ -н үзүүлэх үйлчилгээ: Гишүүдэд уг баримт бичгийн 3-р зүйлд заасан хөнгөлөлт, үйлчилгээг үзүүлнэ.

2.6 Эрх үүрэг: **Гишүүн нь ММЗИ-ийн Ёс зүйн дүрмийг зөвлөхийн үйл ажиллагаандаа чанд мөрдөх үүрэгтэй.** Мөн гишүүн нь ММЗИ-н үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, санал сэтгэгдлээ чөлөөтэй илэрхийлэх, хамтран ажиллах/туслах, ММЗИ-ийн санхүү болон үйл ажиллагааны талаарх мэдээлэлтэй танилцах, гишүүнчлэлийн төрлөөс хамаарч ММЗИ-ийн хариуцлагатай албан тушаалуудад нэр дэвших эрхтэй.

2.7 Мэдээллийн нууцлал: Гишүүний эрхийн дагуу олгогдож буй бүтээгдэхүүн үйлчилгээ, мэдээ мэдээллийг ММЗИ- н зөвшөөрөлгүйгээр бусдад түгээх, ашиглах, заран зарцуулахыг хориглоно.

3. ҮЙЛЧИЛГЭЭ БА ХӨНГӨЛӨЛТ

1.4 Гишүүнээр элссэн иргэнд (хувь гишүүн) үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ ба хөнгөлөлт үзүүлнэ.

№	Бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл / төлбөр ба хөнгөлөлт	Суралцагч гишүүн (Student Member) /Жилийн хураамж 50,000₮/	Мөнгөн гишүүн (Silver Member) /Жилийн хураамж 300,000₮/	Алтан гишүүн (Gold Member) /Жилийн хураамж 500,000₮/	Цагаан алтан гишүүн (Platinum Member) /Жилийн хураамж 900,000₮/
A	**ММЗИ-ийн төлбөртэй үйлчилгээнд эдлэх хөнгөлөлт**				
1.	ММЗИ-ээс зохион байгуулсан төлбөртэй сургалтанд (гишүүнчлэлийн төлбөрийн 50%-с багагүй үнийн дүнтэй) суусан бол тухайн жилийн гишүүнчлэлийн хураамжийн төлбөрөөс хөнгөлөх хувь	100%	70%	50%	30%
2.	ММЗИ-ийн зөвлөхийн үндсэн ур чадварын сургалтын төлбөрөөс хөнгөлөх хувь	5%	10%	15%	20%
3.	ISO 20700 стандартын сургалтад хөнгөлөлт эдлэх хувь /3 сарын дотор цол авсан бол зөрүүг буцаан олгоно./				
	- ММЗИ -н цолгүй гишүүн бол	15%	20%	30%	50%
	- МСМС цолтой бол	15%	20%	30%	50%
	- СМС цолтой бол	15%	20%	30%	50%
4.	ММЗИ-ийн сар бүрийн вэбинарын төлбөрийн хөнгөлөлтийн хувь	100%	100%	100%	100%
5.	ConsultCon Зөвлөхүүдийн Чуулганд оролцох такс, хөнгөлөлтийн хувь	50% /100%-сайн дурын ажилтан бол/	100%	100%	100%
6	ММЗИ-ийн бусад төлөвлөгөөт бус төлбөртэй сургалт, аялал, арга хэмжээнд оролцох төлбөрийн хөнгөлөлтийн хувь	5%	10%	15%	20%
B	**ММЗИ-ээс олгох гишүүдэд олгох бүртгэл, гэрчилгээжүүлэлтийн боломжууд**				
7.	ММЗИ вэб сайтад зөвлөхийн танилцуулга, үйлчилгээ, холбоо барих мэдээлэл байршуулах	x	√	√	√
8.	ММЗИ-ээс олгодог Mongolian Certified Management Consultant (MCMC) цол, тэмдэг, гэрчилгээжүүлэлтэд хүсэлт гаргах эрх	x	x	√	√
9.	ICMCI Менежментийн зөвлөх институтуудын Олон улсын консулаас олгодог CMC цол, тэмдэг, гэрчилгээжүүлэлтэд хүсэлт гаргах эрх	x	x	x	√
C	**ММЗИ-ийн гүйцэтгэх баг, хороод, удирдах зөвлөлд элсэх, нэр дэвших боломжууд**				
10.	ММЗИ –Сайн дурын ажил хийх	√	√	√	√
11.	ММЗИ –Гүйцэтгэх багт элсэх		√	√	√
12.	ММЗИ –Хороодын гишүүнээр элсэх		√	√	√
13.	ММЗИ –Хороодын даргад нэр дэвшүүлэх			√	√
14.	ММЗИ - Удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх				√
15.	ММЗИ -ийн Харилцагч нар зөвлөхийг санал болгох.		√	√	√

1.5 Гишүүнээр элссэн байгууллагад үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ ба хөнгөлөлт үзүүлнэ. Нэг байгууллагаас хамрагдах 3 гишүүн тутамд нэг байгууллагын гишүүний төлбөр хураамж төлнө. Өөрөөр хэлбэл байгууллагаар гишүүнчлэлд элссэн бол байгууллагын гишүүнчлэлийн төлбөртөө өөрийн 3 хүртэлх зөвлөхийг бүртгүүлэх, холбогдох хөнгөлөлт эдлэх боломжтой (тухайн байгууллага дээрх 4 дэх зөвлөхөөс эхлэн зөвлөх тус бүр нэмэлтээр иргэн, хувь гишүүний төлбөр төлнө).

№	Бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл / төлбөр ба хөнгөлөлт	Мөнгөн гишүүн (Silver Member) /Жилийн хураамж 600,000₮/	Алтан гишүүн (Gold Member) /Жилийн хураамж 900,000₮/	Цагаан алтан гишүүн (Platinum Member) /Жилийн хураамж 1200,000₮/
A	**ММЗИ-ийн төлбөртэй үйлчилгээнд эдлэх хөнгөлөлт**			
1.	ММЗИ-ээс зохион байгуулсан төлбөртэй сургалтанд (гишүүнчлэлийн төлбөрийн 50%-с багагүй үнийн дүнтэй) суусан бол тухайн жилийн гишүүнчлэлийн хураамжийн төлбөрөөс хөнгөлөх хувь	70%	50%	30%
2.	ММЗИ-ийн зөвлөхийн үндсэн ур чадварын сургалтын төлбөрөөс хөнгөлөх хувь	10%	15%	20%
3.	ISO 20700 стандартын сургалтад хөнгөлөлт эдлэх хувь /3 сарын дотор цол авсан бол зөрүүг буцаан олгоно./			
	- ММЗИ -н цолгүй гишүүн бол	20%	30%	50%
	- МСМС цолтой бол	20%	30%	50%
	- СМС цолтой бол	20%	30%	50%
4.	ММЗИ-ийн сар бүрийн вэбинарын төлбөрийн хөнгөлөлтийн хувь	100%	100%	100%
5.	ConsultCon Зөвлөхүүдийн Чуулганд оролцох такс, хөнгөлөлтийн хувь	100%	100%	100%
6	ММЗИ-ийн бусад төлөвлөгөөт бус төлбөртэй сургалт, аялал, арга хэмжээнд оролцох төлбөрийн хөнгөлөлтийн хувь	10%	15%	20%
B	**ММЗИ-ээс олгох гишүүдэд олгох бүртгэл, гэрчилгээжүүлэлтийн боломжууд**			
7.	ММЗИ вэб сайтад зөвлөхийн танилцуулга, үйлчилгээ, холбоо барих мэдээлэл байршуулах	√	√	√
8.	ММЗИ-ээс олгодог Mongolian Certified Management Consultant (MCMC) цол, тэмдэг, гэрчилгээжүүлэлтэд хүсэлт гаргах эрх	x	√	√
9.	ICMCI Менежментийн зөвлөх институтуудын Олон улсын консулаас олгодог CMC цол, тэмдэг, гэрчилгээжүүлэлтэд хүсэлт гаргах эрх	x	x	√
C	**ММЗИ-ийн гүйцэтгэх баг, хороод, удирдах зөвлөлд элсэх, нэр дэвших боломжууд**			
10.	ММЗИ –Сайн дурын ажил хийх	√	√	√
11.	ММЗИ –Гүйцэтгэх багт элсэх	√	√	√
12.	ММЗИ –Хороодын гишүүнээр элсэх	√	√	√
13.	ММЗИ –Хороодын даргад нэр дэвшүүлэх		√	√
14.	ММЗИ - Удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх			√
15.	ММЗИ -ийн Харилцагч нар зөвлөхийг санал болгох.	√	√	√

4. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТӨРӨЛ БА ХУРААМЖ

4.1 Гишүүнчлэлийн төрөл, хураамж ба төлбөрийн нөхцөл

ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТӨРӨЛ	ХУРААМЖИЙН ДҮН ХУВЬ ХҮН	БАЙГУУЛЛАГА
ЦАГААН АЛТАН (PLATINUM)	900 000 ₮ /есөн зуун мянга/	1,200,000₮ /3 хүн тутамд, эсвэл 4 дэх зөвлөхөөс эхлэн зөвлөх тус бүр нэмэлтээр иргэн, хувь гишүүний төлбөр төлөх).
АЛТАН (GOLD)	500 000₮ /таван зуун мянга/	900,000₮ /3 хүн тутамд
МӨНГӨН (SILVER)	300 000₮ /гурван зуун мянга/	600,000₮ /3 хүн тутамд
СУРАЛЦАГЧ (STUDENT)	50 000₮ /тавин мянга/ (Сайн дурын ажилтан хийж төлбөрөө 100% хөнгөлүүлэх)	NA

4.2 Гишүүд нь жил бүр гишүүнчлэлийн хураамжийг төлснөөр тухайн төрөлд ногдох гишүүний хөнгөлөлт болон бусад эрхийг эдэлнэ. Мөн ММЗИ-н Гишүүний гэрчилгээг хүлээн авна.

4.3 Гишүүн нь анх сонгосон гишүүнчлэлийн ангиллыг дээшлүүлж болох бөгөөд ингэхдээ анх хураамж төлснөөс хойш 3 сарын дотор өөрчилж болно. Уг ангилал нь анх хураамж төлж элссэн хугацаанаас хойш 12 сар байна.

4.4 Гишүүний төрлийг ахиулах хүсэлтэй тохиолдолд, ММЗИ-н Гүйцэтгэх удирдлагад 3 сарын хугацаагаа дуусахаас өмнө имэйл эсхүл албан бичгээр хүсэлтээ мэдэгдэнэ.

4.5 Гишүүний хугацааг дуусахаас 30 хоногийн өмнө ММЗИ сануулга, нэхэмжлэх илгээнэ. Нэхэмжлэхийн дагуу, Гишүүнчлэлийн хураамжийн төлбөрийг хийснээр гишүүний ашиг тусыг үргэлжлүүлэн хүртэх боломжтой.

5. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖИЙГ БАРТЕРААР БОЛОН БУСАД НӨХЦЛӨӨР ТӨЛӨХ, ХӨНГӨЛҮҮЛЭХ БОЛОМЖ

5.1 Гишүүд нь тухайн жилийн гишүүнчлэлийн хураамжаа ММЗИ-ийн гүйцэтгэх удирдлага, оффисын үйл ажиллагаанд шаардлагатай дараах үйлчилгээгээр бартер хийх боломжтой. Үүнд:

- 5.1.1 Санхүү, татвар, НДШ-ийн сар, улирал, жилийн тайлан гаргах
- 5.1.2 Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх
- 5.1.3 Вэбсайт, сургалтын платформ хийх, хөгжүүлэх, холбогдох сайжруулалтыг хариуцах
- 5.1.4 Сургалт, арга хэмжээ зохион байгуулах, оффист шаардлагатай талбайгаар хангах
- 5.1.5 Вэбинарт зочин илтгэгчээр оролцох
- 5.1.6 Сургагч багшаар ажиллах
- 5.1.7 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалт, воркшоп, ConsultCon зөвлөхийн чуулган зэрэг үйл ажиллагаанд туслах
- 5.1.8 Маркетингийн үйл ажиллагаанд туслах
- 5.1.9 Удирдах зөвлөл, Гүйцэтгэх хороод, Гүйцэтгэх багт ажиллах
- 5.1.10 ММЗИ-ийн зорилгод нийцэх, үйл ажиллагаанд шаардагдах бусад бүтээгдэхүүн үйлчилгээ (гишүүд санал болгох боломжтой)

5.2 Тухайн жилд үйл ажиллагаанд шаардлагатай бартерын төрөл, хэмжээ хязгаартай ба үүнд ММЗИ-ийн Гүйцэтгэх баг ба Удирдах зөвлөл хяналт тавина.
5.3 Бартерын үйлчилгээнд жишиг шаардлага (цагийн гм) ба дуйцэх хөнгөлөлтийг гүйцэтгэх баг, эсвэл удирдах зөвлөлийн санаачлагаар удирдах зөвлөл хэлэлцэж тогтоно.
5.4 Гишүүд гишүүнчлэлийн төлбөрөө бүрэн, эсвэл зарим хэсгийг бартерын нөхцлөөр (бүтээгдэхүүн, үйлчилгээ, оролцоо гм) төлөх хүсэлтэй бол хүсэлтээ ММЗИ-н Гүйцэтгэх багт гаргана. Гүйцэтгэх баг хүсэлтийг хүлээн авч (Цахим бүртгэлийн маягтаар) Удирдах зөвлөлд танилцуулж, зөвшөөрөл авснаар хэрэгжинэ.

6. ЦУЦЛАЛТ, БУЦААН ОЛГОЛТ

6.1 Гишүүний хураамж болон бусад үйлчилгээний төлбөрийг буцаан олгохгүй (Ямар нэг гомдол гараагүй бол).

6.2 Гишүүний хураамжаа төлөөгүй бол гишүүнчлэлийн холбогдох хөнгөлөлтүүдийг эдлэхгүй. Гишүүнчлэлийн бүртгэлээс хасагдана.

7. БУСАД

7.1 Гишүүн нь өөрийн, эсхүл өөрийг нь төлөөлөн голлон харьцах хүний, мэдээллийг ММЗИ-д Гишүүнээр элсэхдээ тодорхойлох ба цаашид ММЗИ-н зүгээс гишүүддээ түгээх бүх мэдээ, мэдээлэл, холбоо барих зэрэг нь тухайн контактаар дамжина.
7.2 Гишүүд гишүүнээр элсэх үедээ, мөн жил бүр үйл ажиллагаанд нь гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг ММЗИ-д өгөх ба энэ дагуу холбогдох бүртгэлийн мэдээллийг шинэчилнэ (вэб дээрх болон бусад).

ММЗИ-н гишүүнчлэлдээ ТАВТАЙ МОРИЛНО УУ.

~ ● ~

ХАВСРАЛТ

Нэр томьёоны тайлбар

Нэр томьёо	УТГА
Бартер	Гишүүнчлэлийн төлбөрөө мөнгөн бус хэлбэрээр төлөх, орлуулах
Гишүүн	Гишүүнчлэлийн хураамж төлсөн хувь хүн/ байгууллага
Гишүүний хураамж	ММЗИ-н гишүүн байхыг хүсч буй хувь хүн/ байгууллагын төлбөр
Гишүүний төрөл	Цагаан алтан, Алтан, Мөнгөн, Суралцагч
Нийт гишүүд	Гишүүнчлэлийн хураамж төлсөн бүх хувь хүн/ байгууллага
Сонирхогч	ММЗИ-н үйл ажиллагааг сонирхдог, оролцдог боловч Гишүүнчлэлийн хураамж төлөөгүй хувь хүн/байгууллага
Төлбөр	Гишүүний хураамжаас бусад төлбөр (жишээлбэл, сургалтын төлбөр)
Удирдах зөвлөл (УЗ)	Нийт гишүүдийн санал хураалтаар сонгогдсон зөвлөл
Удирдах зөвлөлийн гишүүн	Нийт гишүүдийн санал хураалтаар УЗ-д сонгогдсон гишүүн
Гүйцэтгэх хороо	ММЗИ-ийн удирдах зөвлөлөөс баталсан тодорхой үйл ажиллагааны бодлого, чиглэл, гүйцэтгэл хариуцсан баг (Сургалтын хороо, Гишүүнчлэлийн хороо, Гэрчилгээжүүлэлтийн хороо, Төсөл хөтөлбөрийн хороо, Нэр дэвшүүлэх хороо, Ёс зүйн хороо, Маркетингийн хороо гм)
Гүйцэтгэх баг, оффис	ММЗИ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг Гүйцэтгэх захирал, Үйл ажиллагааны менежер, Нябо болон бусад ажилтан
Хамтрагч	ММЗИ-тэй хамтын ажиллагаатай хувь хүн/ байгууллага
Харилцагч	ММЗИ-н зөвлөх болон зөвлөхүүдийн үйлчилгээг хүсэгч хувь хүн/ байгууллага